

УЛС ТӨР, ҮЗЭЛ СУРТАЛ

Э. Пунцаг

**АФГАНИСТАНЫ ДӨРӨВДҮГЭЭР САРЫН
ХУВЬСГАЛ
(Гурван жилийн ойд нь)**

Нийгмийн хөгжлийн гарцаагүй хууль тогтлын дагуу урагшлан ахиж Афганистанд хэмжээт эрхт хаант төрийг, Иранд Шагийн хэмжээгүй эрхт дэглэмийг тус тус халсан Афган, Ираны 1978-1979 оны хувьсгал аль аль нь эрин үеийн дэлхийн хувьсгалт үйл явцын бодит үргэлжлэл бөгөөд түүний нэг салшгүй хэсэг нь юм. Чухам үүнд 70-аад оны Афган, Ираны хувьсгалын олон улсын ач холбогдол оршино.

Эдгээр хувьсгал нь гол агуулгаараа империализм, феодализм, харгислалыг эсэргүүцсэн үндэсний ардчилсан хувьсгал юм. Ийм учраас ч өнөө үед АНУ тэргүүтэй империалист хүч, түүний хань хавсрага болсон хятадын маоистууд Афган, Ираны хувьсгалыг лалын ертөнцөд түгэн хооронд нь салган хөндийрүүлж болбол нэг нэгийнх нь эсрэг хандуулах, улмаар дарж устгахыг чармайж байна.

Афганистан нь аугааих Октябрийн нөлөөгөөр Ази, Дорно дахинд империализмыг гинжийг тас цохиж үндэсний эрх чөлөөний хөдөлгөөний сэрэх явдалд үлгэр үзүүлж гараагаа эхэлсэн анхны орнуудын нэг юм. Афганистаны ард түмний энэхүү ариун шударга үйлсэд нь анхнаасаа тусалсан хань бол түүний умард хөрш агуу их Оросын ард түмэн юм.

Шинэ залуу Зөвлөлт Орос улс Афганистаны Бүгд Найрамдах Улсыг 1919 онд найрсгаар хүлээн зөвшөөрсөн нь Афганистаныг хууль ёсоор хүлээн зөвшөөрсөн анхны цорын ганц улс байв. Төв Азид стратегийн чухал ач холбогдол бүхий уулзвар газар нутагтай болохоор Афганистан нь хэзээнээс нааш өрнө зүгийн колоничлогч, империалист гүрний түрэмгийлэлд өртөж тэдний хараат буюу хагас колони болоход хүрч байв.

Афганистаны тусгаар тогтнолыг англи-афганы гуравдугаар дайнаар ялагдсан Англи улс 1919 оны наймдугаар сарын 19-нд арга буюу хүлээн зөвшөөрчээ. Энэ нь дэлхий дахинд империализм ганцаар ноёрхох ёсыг эвдэж колони орон, ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолыг дэмжсэн аугаа их Октябрийн хувьсгалын ач нөлөө юм. Гэтэл Афганистаныг Англи зэрэг өрнөдийн гүрнүүд «протекрат» ивгээл тэтгэмжиндээ байлгаж залуу Зөвлөлт Оросын эсрэг түрэмгийллийн голомт, түшиц газар болгож ашиглахыг оролдож билээ.

Ийм тодорхой нөхцөлд Зөвлөлт улс өөрийн баруун өмнөд хөрш Афганистаны ард түмэнд эдийн засаг, санхүү, батлан хамгаалах талын тусламжийг хүртэл сэтгэл харамгүй үзүүлсээр иржээ. Афганистан ч чухал үед шаардагдах тусламжаа хөрш Зөвлөлт улсаас хүсдэг, түүнийг нь Зөвлөлт улс найдвартай биелүүлж ирсний дүнд Зөвлөлт-Афганы хооронд анхнаасаа эхлэн найрамдалт хөршийн харилцаа, нийгмийн өөр өөр системтэй улс гүрнүүд энх тайвнаар зэрэгцэн орших олон улсын шинэ маягийн харилцааны эх үүсвэр тавигджээ.

1921 оны 2-р сарын 24-нд Зөвлөлт-Афганы энх тайвны гэрээ байгуулагдаж тэр өдрөөс өнөөдөр хүртэл энэ хоёр орны эвт хөршийн найрсаг харилцаанд хир толбо суугаагүй бөгөөд тийм шалтгаан гарах ёс ч үгүй юм. Гагцхүү тэр үед Английн эрх баригч бүлэг, эдүгээ үед АНУ тэргүүтэй империалист хүчний талынхан Зөвлөлт Афганы найрсаг харилцаанд дургүйцэж тэрхүү 20-аад оны үед «улааны аюул» гэгчийг ухуулга ятгалгандаа хэрэглэж байсан бол энэ 80-аад онд «умардын аюул» гэгч хий үзэгдлээр Зөвлөлт-Афганы харилцааг гутаахыг хичээж байна. Үүнд хэргийн гол учир нь Афганистаны нийгмийн хувьсгалд дайсагнаж байгаатай л холбогдох юм. Афганистан дээр дурдсанчилан Ази, Дорно дахинд империалист колоничлолыг одоогоос 60 гаруй жилийн өмнө таягдан хаясан хувьсгалт уламжлалтай бол одоо Ази тивээр зогсохгүй даян дэлхийн лалын мөргөлт улс түмний дотроос хүн хүнээ мөлжихгүй тэгш эрхт ёсыг тунхаглан тогтоож буй анхны орон боллоо. Чухам энэ зүй зохист үзэгдэл эрин үе дэх империализм, социализм хоёрын зөрчил, ангийн тэмцлийн хурцдалыг илэрхийлж байгаа нь Афганистаны хувьсгалд хандаж буй улс гүрний өнөөгийн хандлагаас харагдаж байна.

Бүр 1919 онд В.И.Ленин тусгаар тогтносон Афганистаны элч төлөөлөгчдийг нэг биш удаа хүлээн авч уулзахдаа Афганистаны ард түмнээс империализмын эсрэг явуулж буй шударга тэмцэлд нь баяр хүргэж зайлшгүй шаардагдах тусламжийг нь заавал үзүүлэх талаар Зөвлөлт засаг санаа тавьж байжээ.

Зөвлөлт засгийн тэргүүнээс Афганы эмир Аманнулла-ханы захидлын хариуд: «Өнөө үеийн цэцэглэн буй Афганистан бол дэлхийн лалын шашинтай цорын ганц тусгаар тогтносон улс бөгөөд лалын шашинтай бүх дарлагдсан ард түмнийг өөрийгөө тодруулан нэгтгэн тэднийг эрх чөлөө тусгаар тогтнолын замд хөтлөх хувь заяа Афганы ард түмэнд ноогдож байна» гэсэн ариун утгатай, ашдын билэгтэй сайхан сургаалтай захидал байдаг ажээ.¹

Афганы ард түмэн энэ яруу алдарт үйлсээ нэр төртэй үргэлжлүүлж байгаа бөгөөд тэгэх тусам Араб дорнодын эрин үеийн үндэсний эрх чөлөөний хөдөлгөөн, социализм, коммунизмын эсрэг хүчний ноцтой эсэргүүцэлтэй тулгарч буйг Афганистаны ардчилсан хувьсгалын өнөөгийн шатууд гэрчилнэ. Энэ нь нөгөө талаар Афганы хувьсгалд тохиолдож буй бэрхшээл боловч харин түр зуурын асуудал юм. Афганы хувьсгалын дайснууд, хувьсгалын эсэргүү нар уг хувьсгалын ялалтыг угаасаа хүсээ ч үгүй бөгөөд одоо нэгэнт ялсан хойно түүний дотоод дахь хөгжилтийн цаашдын шат үе, гадаад дахь нөлөөг газар авахуулахгүй зогсоох, чадвал, хувьсгалыг даран устгаж хуучин дэглэмийг сэргээх зорилготой юм.

Афганистан тусгаар тогтнолоо сэргээсний дараа ч гэсэн ард түмэн нь удаан хугацаанд түүний үр шимийг хүртэж чадахгүй байв. Засгийн эрхийг газрын эзэд, феодал язгууртны дэмжлэгтэйгээр гартаа авсан Надир шаг дангаар ноёрхох харгис дэглэм тогтоосон нь даруй шагийн болон вангийн төрийн элдэв хэлбэрээр үе залгамжлан захирсаар хэрэг дээрээ 1978 оны дөрөвдүгээр сарын хувьсгалаар унагаагдсан Даудын дэглэмээр төгсгөл болжээ. Орон даяар улс төрийн харгислал ноёрхохын хажуугаар эдийн засгийн дарлал мөлжил туйлдаа хүрч бүх 16 сая хүн амын 80 гаруй хувийн эрхэлдэг аж ахуй нь феодалын хоцрогдмол аж ахуй байв. Хүн амын энэ дийлэнх олонхи болох тариачдын амьдрал ахуй хуучин дэглэмийн үед феодал, хамжлагын тариачдын хэмжээнд, зарим талаар эцгийн эрхт ураг аймгийн холбоо зэрэг феодалын түрүү буюу өмнөх үеийн түвшинд оршиж байв.

¹С. Ю. Выгодский. У истоков советской дипломатии. М., 1965. с. 270-д үзнэ үү.

Газар эдэлбэрийн хувьд бол газрын жижиг, дунд эзэд бүх газрын 50 хувийг эзэмшиж, нөгөө 50 хувийг нь хүн амын дөнгөж 5 хувийг эзлэх 40 мянга орчим тооны газрын том эзэд язгууртнууд эзэмшиж байжээ.

Нам, үйлдвэрчин зэрэг олон түмний байгууллагыг хуучин дэглэм хуулиар хориглож гагцхүү лалын шашны сүмийн үүд л хүн амд нээлттэй байв. Афганистаны улс төрийн хэвлэл, утга зохиолд нам гэдэг үг улс төрийн агуулгаараа гарах болсон үе бол чухамдаа 1950-аад оны сүүлч 60-аад он бөгөөд энэ үед афганы дэвшилт сэхээтнүүд, хувьсгалчдын байгууллага сонин хэвлэлээрээ дамжуулан феодалыг эсэргүүцсэн хувьсгалыг хурцаар сурталчилж, феодал ёс амь бөхтэй зууралдсан Афганистаны нөхцөлд ажилчин ангийн намаас мөлжигч дэглэмийн эсрэг армийн туслалцаатайгаар хийх тэмцэл бололцоотойн тухай үзэл санааг дэвшүүлж байв. Шинжлэх ухааны социализм, ажилчин ангийн нам, ардчилсан хувьсгалын зэрэг үзэл санааг нэвтрүүлсэн нь Афганистаны Ардын Ардчилсан Нам (АААН)-тай шууд холбоотой билээ.

Энэ намын анхдугаар их хурал түүнийг үүсгэн байгуулагчийн нэг Нур Мухаммед Таракийн санаачилгаар 1965 оны нэгдүгээр сарын 1-нд (афган он тооллын 1343 оны Жаддийн 11) хуралдаж Н. М. Таракийг АААН-ын Ерөнхий нарийн бичгийн даргаар, Бабрак Кармалийг түүний орлогчоор санал нэгтэй сонгожээ.

Н. М. Тараки тэргүүтэй АААН Афганистаны тухайн нөхцөлд нам ард түмний холбоо, ард түмнээс хувьсгалд хандах хандлага, нэг үгээр хэлэхэд хувьсгалын тохироо, урьдчилсан нөхцөл зэрэг асуудлыг онол практикийн үүднээс судлан боловсруулж ноёрхон буй харгис дэглэмийг гагцхүү ард түмний хувьсгалаар түлхэн унагаж болох ба хувьсгалыг ажилчин ан-гийн нам удирдах ёстойг тодорхойлжээ. Капитализм гүнзгийрэн хөгжөөгүй феодалын харилцаатай зууралдсан аливаа нийгэмд ажилчин ангийн шинэ маягийн намаар удирдуулсан ардын* буюу үндэсний ардчилсан хувьсгалын дүнд тогтсон улс нь хэлбэрийн хувьд ардчилснаар барахгүй саргач (жууч) хөрөнгөтөн, империализмыг эсэргүүцсэн агуулгаараа капитализмыг алгасч социалист чиг баримжааг дамжин аажмаар социалист шинэ нийгэмд шилжих хамгийн дөт дөхөм зам гэдгийг Ази, Африкийн зарим орнуудын туршлага бэлхнээ харуулж байна. Гэвч өнөөгийн Афганистаны тодорхой нөхцөлд социализмыг байгуулах программыг ойрын зорилго болгож аваагүйгээрээ АААН-ын удирдагчид дээрх зүй тогтол, үе шатуудыг үгүйсгэсэн нь биш, харин гол үндэс болгож ирэв. Ийм ч учраас «одоогийн таван жилийн төлөвлөгөө (1979-1984)-г биелүүлсний дараах 6-10 жилийн дотор тус орон нийгэм эдийн засгийн социалист бүтцийг бүрэлдүүлэх бололцоотой болно»² гэж АААН-ыг үндэслэн байгуулагч афганы ард түмний гарамгай хүү Н. М. Тараки агсаны хэлсэн билэг дэмбэрэлтэй үг биелэгдэх цаг ирэх болно. Үүнтэй холбогдуулан дурдахад АААН-ын Төв Хорооны Ерөнхий нарийн бичгийн дарга, Хувьсгалт Зөвлөлийн дарга, БНААфГУ-ын ерөнхий сайд Бабрак Кармаль хэлэхдээ: «Улс үндэстний асуудал, соёлын хувьсгалын асуудлыг шийдвэрлэхдээ хөгжлийн капиталист шатыг алгасан феодализмаас социализмд шилжин орсон Монголын туршлагад бид тулгуурлаж байна»³ гэжээ. Монгол афганчууд аль аль нь хэзээнээс нааш бие биеэ мэдэх бөгөөд хоёул Зөвлөлт улстай өргөн уудам газраар хил нийлж ирсэн учир түүнтэй нийгэм эдийн засаг, соёлын бүхий л талаар харилцан холбогдсон түүхээр маш баялаг ард түмэн юм.

*Дөрөвдүгээр сарын хувьсгалыг ардын ардчилсан гэж болох бүрэн үндэстэйн талаар Б. Кармалийн бичсэн өгүүлэл, «Проблемы мира и социализма», 1980. № 4-т нийтлэгджээ.

³«Үнэн», 1980 оны гуравдугаар сарын 25.

1978 оны дөрөвдүгээр сарын 17-нд мандсан Афганы хувьсгал нь Ази тивийн эртний түүхт энэ орны ард түмний түүхэнд яруу алдарт шинэ хуудас нээсэн юм. Афганистанд газрын шинэтгэл явуулах тухай хуулийн төслийг 1978 оны арван нэгдүгээр сард АААН-ын Төв Хорооны бүгд хурлаар хэлэлцэн сайшааж улмаар төрийн захиргааны дээд эрхийг барих Хувьсгалт Зөвлөлөөр хэлэлцэж зарлиг (№ 8) баталжээ. 1978 оны арван хоёрдугаар сарын 27-ноос эхлэн эхний ээлжинд өмнөд, зүүн өмнөд, баруун талын мужуудад газрын шинэтгэл явуулжээ. 1980 оны эхний байдлаар огт газаргүй буюу бага газартай 285 мянган тариачдад 3 сая гаруй жериб (1 жериб==0,2 га) газар олгосон⁴ ба үүгээр газрын шинэтгэлийн эхний шат амжилттай дуусч төв ба зүүн мужуудад газар хуваарилах 2-р ээлжинд эхэлж оржээ.

АААН, засгийн газрын нийгэм-эдийн засгийн бодлогын нэг чухал ололт нь тэнд газрын шинэтгэлийн программыг хэрэгжүүлэх явц дунд сангийн аж ахуй байгуулж, улсын фондын газар бий болгосон явдал юм. Газрын шинэтгэл нь зохион байгуулалтын өндөр хэмжээнд явагдаж газрыг тариачдад үнэ төлбөргүй хувааж өгсөн нь хөдөөгийн хүн амыг хувьсгалын талд татаж орон нутагт феодалын харилцааны эдийн засгийн үндсийг устгаж хүн хүнээ дарлан мөлждөггүй нийгмийн үндэс суурийг тавьсан байна.

Эдгээр арга хэмжээний дүнд Афганистанд газар тариалангийн хувьсгал амжилттай явагдаж олон зуун жилээр зонхилж ирсэн феодалын үеийн газар эзэмшлийн үхширмэл системийн үүрт устгаж, газрыг жинхэнэ газар дээрээ ажилладаг хөдөлмөрч тариачдад шилжүүлжээ. Газар шинэтгэлийн хуулийг биелүүлсэн үндсэн дээр Афганистанд хоршооллын хөдөлгөөн өрнөж 1979 оны тоогоор 540 мянга гаруй жериб газартай 964 хоршоолол байгуулагдсанд тус орны хөдөөгийн хөдөлмөрчдийн 140 мянга орчим айл өрхийг хамарч байна.⁵

Дөрөвдүгээр сарын хувьсгал Афганистаны нийгэм эдийн засгийн бүхий л салбарт өргөн далайцтай өрнөж засгийн газрын зарлиг ёсоор хуучин дэглэмийн үед шорон гянданд улс төрийн хэргээр хоригдож байсан 5,5 мянган хүнийг суллан цагаатгасан ба үйлдвэр аж ахуйн газруудыг түшиглан үйлдвэрчний эвлэлүүд, төв орон нутагт эмнэлэг, эрүүлийг хамгаалах газрууд байгуулан ядуучуудыг үнэ төлбөргүй үйлчлэх болсон зэрэг нь ард түмний урам зориг, хувьсгалч идэвхийг улам сэргээсэн байна. Хувьсгалт зөвлөл ардын боловсролын салбарт онцгой анхаарал тавьж, хувьсгалын дараахи эхний ганцхан жилийн дотор 7-50 хүртлэх насны 1 сая гаруй хүнийг бичигтэн болгоод зогсонгүй ойрын жилд бүх нийтийн анхан шатны боловсрол эзэмших зорилт тавьжээ. Хувьсгалын өмнө цөм эрх мэдэлгүй байсан хазар (афганы монголчуудын удам-зохиогч), узбек, туркмен, нур, белуж, тажик, киргис зэрэг цөөнх үндэстэн одоо тэгш эрх эдэлж узбек, туркмен, белуж хэл дээр сонин гаргаж, радио нэвтрүүлэг явагддаг болжээ.

Хувьсгалт зөвлөлөөс хувьсгалын эхэн шатанд авсан зарчмын чанартай нэг томоохон арга хэмжээ бол 1979 оны гуравдугаар сарын 21-нд батлагдсан анхны таван жилийн төлөвлөгөө (1979-1984) бөгөөд түүгээр улс ардын аж ахуйн хөгжилдөө үндсэн өөрчлөлт хийх зорилт дэвшүүлсэн явдал мөн. Эдийн засгийг төлөвлөгөөтэй хөгжүүлэх хууль бол Афганистаны нийгмийн харилцааг өөрчлөхөд чухал нөлөө үзүүлнэ.

⁴А. Н. Игнатов. Революция, рожденная в Апреле. Изд-во «Вост. Литературы» М. 1980. с. 69. 1980 оны сүүлчээр хуваарласан газар 665 мянган га, хуваарьт орсон өрх 296 мянга болжээ. («Азия и Африка сегодня» 1981. № 1. с. 6).

⁵«Үнэн» 1979 оны наймдугаар сарын 7.

Агуу их зөвлөлтийн ард түмэн, түүний засгийн газар нь В.И.Лениний бичсэнээр «эв найрамдал, ах дүүгийн барилдааны гараа дорно зүгийн бүх ард түмэн, түүний дотор эн тэргүүнд афганы ард түмэнд сунгасан»⁶ бөгөөд одоо ч сунгасаар байна. Үүнтэй холбогдуулан Зөвлөлт засгийн газраас тусгаар тогтносон Афганистанд анх 1920 онд буцалтгүй тусламжаар байгуулж бэлэг болгосон тухайн үедээ хамгийн шинэ техник төхөөрөмжтэй радио станцаас эхлээд 50-60 жилийн туршид үзүүлсэн тал бүрийн тусламж түүний дотор зам тээвэр, уул уурхай, эрчим хүч, хөнгөн хүнсний зэрэг гол төлөв 60-70-аад онд ЗХУ-ын хүч хөрөнгөөр сүндэрлэн боссон 140 гаруй дунд ба том хэмжээний орчин үеийн барилга, үйлдвэрүүдийг дурдахад хангалттай юм. ЗХУ-ын эдгээр сэтгэл харамгүй тусламж нь Афганистаны үндэсний эдийн засагт шинэ шинэ салбар буй болгох, ялангуяа улсын секторыг үүсч бүрэлдэхэд үнэлж баршгүй хувь нэмэр оруулсан нь эдүгээ эдгээр барилга байгууламжууд нь Афганистанд байгаа аж үйлдвэр, соёлын газруудын 70 хувийг эзэлж буйгаас⁷ илэрхий байна. Афганистаны үйлдвэр аж ахуйн газруудад үндэсний мэргэжилтэн ажиллаагүй тийм салбар одоо нэгэнт үгүй болсон нь орчин үеийн шинжлэх ухаан техникийн хөгжлийн дагуу мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх талаар олж буй том амжилтын нэг юм.

Афганы дөрөвдүгээр сарын хувьсгал нь Афганистаны нийгмийн дотоод түүхэн хөгжлийн зүй тогтолт үр дүн бөгөөд хувьсгалын ялалтанд шалтгаалсан гадаад хүчин зүйл нь 1917 онд орос оронд мандсан Октябрийн хувьсгалаар эх нь тавигдсан агуу их хувьсгалт үйл явцыг олон улсын империализмын зүгээс хар хүчээр таслан зогсоож чадахгүй болсон эрин үеийн онцлог юм. Гэвч хувьсгалын цаашдын шат үе, АААН, Хувьсгалт зөвлөлөөс авч явуулсан нийгэм-эдийн засгийн дэвшилт өөрчлөлт гадна дотнын элдэв саад бэрхшээлтэй тулгарсан юм. Энэ нь юуны өмнө Афганистаны нийгэм эдийн засгийн хоцрогдонгүй байдал⁸ хувьсгалаар унагаагдсан тарлагч ангийн эсэргүүцэл, хувьсгалаас урвагч эсэргүү бүлгийн хорлон сүйтгэх үйл ажиллагаа зэрэг дотоодын саад бэрхшээл байв. «Эрх чөлөөний төлөө тэмцэгчид» гэж өрнөдийн хэвлэлд шуугиулж байгаа дээрэмчид юуны өмнө сургууль гэгээрлийн байгууллагыг бүрэлгэп сүйтгэж зөвхөн 1979 оны байдлаар ардын сургуулийн 1100 байрыг галдан шатааж олон тооны багш нарыг алан хяджээ. Зөвхөн энэ баримт¹⁰ эсэргүү нар хувьсгалын гүнзгийрэлтэд аль зэрэг саад учруулж байгааг харуулж байна. Түүнчлэн намын нэгдэл нягтралыг дотроос нь хагалан бутаргагч, АНУ-ын тагнуулын төв газрын гар хөл болсон Амин ба түүнийг аялдан дагалдагчид АААН, дөрөвдүгээр сарын хувьсгалын үйл хэрэгт асар их хохирол учруулжээ. Амин нь нам засгаас авч явуулж байсан нааштай өөрчлөлтүүдийг завхруулснаараа нам ард түмний холбоонд ноцтой сэв оруулаад зогсоогүй намын үнэнч нөхөд, энгийн номхон хөдөлмөрчдийг үй олноор нь дур мэдэн залхаан цээрлүүлж эхэлжээ. Тухайлбал 1979 оны сүүлийн арав хүрэхгүй сарын дотор намын 2000 гаруй гишүүдийг баривчилж түүнээс 500 орчмыг нь буудан алжээ.¹¹ Амин ар-

⁶С. Ю. Выгодский. Дурдсан зохиол. 293-р тал. «Документы внешней полктяки СССР» т, IV. с. 93-94.

⁷«Үнэн», 1980. гуравдугаар сарын 19. ЗХУ-ын санхүү техникийн тусламжтайгаар Афганистанд үйлдвэр хөдөө аж ахуйн 150 барилга байгууламж, барьсан ба баригдаж байна. (Азия и. Африка сегодня. 1981. № 1. с. 6)

⁸Афганистан нь ардын боловсролын хөгжилтөөр дэлхийд 127 дахь, эрүүлийг хамгаалахын түвшингээр 119 дэх байр эзлэх ба НҮБ-ын тоо бүртгэлээр нэг хүнд ноогдох үндэсний орлого нь 100 доллар хүрдэггүй хамгийн ядуу орны нэгд багтана. «Правда», 1981 оны нэгдүгээр сарын 31.

¹⁰А. В. Игнатов. Дурдсан зохиол. М., 1980. 53-р тал.

¹¹«Правда об Афганистана, Документы, факты, свидетальства. Изд-во. АПН. М., 1980. с. 94-р тал.

мийн дотор олон дахин «цэвэрлэгээ» явуулж Саурын хувьсгалд идэвхтэй оролцсон цэргийн олон тооны боловсон хүчнийг хэлмэгдүүлсний улмаас армийн дайчин чадвар буурахад хүрчээ. Амины хамгийн шившигтэй ялт хэрэг нь тэрээр АААН-ыг үндэслэн байгуулагч дөрөвдүгээр сарын хувьсгалын нэрт удирдагч Нур Мухамед Таракийг даалгавар өгч хорлон алуулсан явдал юм. Ардчилсан Афганистаны нам, төрийн эсрэг аюулт хуйвалдааныг толгойлсон Амины хэргийг шүүн тунгааж 1979 оны 12-р сарын 27-нд түүний дэглэмийг татан буулгаснаар дөрөвдүгээр сарын хувьсгалын шинэ хоёр дахь шат эхэлж энэ үеийг «хувьсгал ард түмнийг аварсан үе» гэж зүй ёсоор нэрлэх болжээ. Бабрак Кармаль тэргүүтэй Афганистаны шинэ удирдлага Амины үед баривчлагдсан 15 мянган хүнийг шоронгоос суллаж, хүнс, өргөн хэрэгцээний барааны үнийг хямдруулах зэрэг олон талын арга хэмжээ яаралтай авсан нь нам ард түмний холбоог сэргээх, ардчилсан өөрчлөлтүүдийг явуулахад гаргасан алдаа завхралыг заллуурахад чухал ач холбогдолтой боллоо. Энэ үндсэн дээр бүх эх оронч, дэвшилт хүчнүүд, хувьсгалын талынхныг багтаасан «үндэсний эх орны фронт байгуулах ардчилсан нөхцөлийг бүрэлдүүлж байна.¹² «Үндэсний эх орны фронт»-ын улс төрийн үндэс нь ажилчин анги, тариачин, хөдөлмөрийн сэхээтний нэгдэл холбоонд орших бөгөөд улс төрийн удирдагч нь ажилчин анги, бүх хөдөлмөрчдийн манлай АААН байх ёстой гэжээ.

Афганистаны хөгжлийн одоогийн шатны хамгийн чухал онцлогийг Бабрак Кармаль: «юуны өмнө ард түмний нэгдэл нягтрал зузаарч феодализм, империализмыг эсэргүүцсэн ардчилсан хувьсгалыг бүрэн ялалтад хүргэх шийдвэр төгс байгаа Афганистаны ажилчин анги болон нийт хөдөлмөрчдийн нам болсон АААН-ын удирдлагаар тус орны үндэсний нэгдсэн фронт байгуулсанд оршиж байна»¹³ гэж тодорхойлсон нь одоо нэгэнт «үндэсний эх орны фронт» хэлбэрээр биелэлээ олж хууль зүйн хүчинтэй болон хэрэгжиж байна.

Хувьсгалт өөрчлөлтүүд хувьсгалын эсэргүү дотоодын дайсан, гадаадын түрэмгийлэгчдийн хорлон сүйтгэх, хагалан бутаргах үйл ажиллагааны тулгарсан тухайн үед хувьсгалын ололтыг хамгаалах сайн дурынхны отряд чухал хэрэгтэй болсон бөгөөд тийм отрядыг ч байгуулжээ. Хувьсгалын хоёрдугаар шатны өөр бас нэг ололт бол АААН-ын дүрмийг баталснаас гадна Хувьсгалт зөвлөлөөс 1980 оны 4-р сарын 14-нд баталж тунхагласан «БНААфГУ-ын үндсэн зарчмууд» болно. Энэхүү 10 бүлэг 68 зүйлтэй баримт бичиг нь Афганистаны төрийн дээд байгууллага «Лояа жирга» (хурал)-гаар БНААфГУ-ын үндсэн хуулийг батлах хүртэл үндсэн хуулийн журмаар мөрдөгдөх бөгөөд түүнд афганы нийгэм улс төрийн шинжийг тодорхойлжээ. Тухайлбал «үндсэн зарчим»-д «БНААфГУ нь Афганистаны лалын хөдөлмөрчин ард түмний тусгаар тогтносон ардчилсан улс» (1-р зүйл) гэдгийг заагаад АААН нь ажилчин ангийн нам ба ажилчин, тариачин, сэхээтний эрх ашгийн дагуу улс нийгмийг улирдан жолоодох улс төрийн хүч (4-р зүйл) гэдгийг тодорхойлжээ.¹⁴ «Үндсэн зарчим»-д зааснаар АААН-ын жанжин шугам нь Афганистанд хүн хүнээ дарлаж мөлжих ёсгүй шударга шинэ нийгэм байгуулах явдал гэж үзжээ. Энэ нь Афганистаны дөрөвдүгээр сарын хувьсгалын ялалт, ололтыг бэх-

¹² «Проблемы Мира и Социализма», 1980. № 4 с. 43.

¹³ «Үнэн» 1980 оны нэгдүгээр сарын 18.

*Хувьсгалын үндэсний ардчилсан шатыг нилээд удаан үргэлжлэх шат гэж АААН үзэж байгаа юм. Учир нь Афганистаны аж үйлдвэрт улс, хоршоололын сектор 40 гаруйхан хувь эзлэх бөгөөд хөдөө аж ахуйд тариачны хувийн жижиг аж ахуй зонхилж байна. («Правда» 1981 оны нэгдүгээр сарын 21).

¹⁴ Fundamental principles. Democratic Republic of Afghanistan. Kabul. April 20. 1980. P. 3.

жүүлж Афганистанд шинэ нийгэм байгуулахад шалгарсан манлай нь АААН гэдгийг харуулж байна.

1980 оны 4-р сарын 21-нд Бабрак Кармаль БНААфГУ-ын төрийн шинэ далбааг мандуулах ёслол дээр афганы хувьсгалыг «феодал, империализм, саргач (жууч) хөрөнгөтнийг эсэргүүцсэн үндэсний ардчилсан хувьсгал» гэж тодорхойлоод «манай эрин үеийн гол хүч болох дэлхийн социалист систем, дэлхий дахины пролетарийн хөдөлгөөн, Афганистан ба дэлхий дахины хөдөлмөрчдийн үнэнч нөхөр, агуу их найрамдалт хөрш ЗСБНХУ аар толгойлуулсан үндэсний ба нийгмийн чөлөөлөх хөдөлгөөнтэй эв санааны эвдэршгүй нэгдэлтэй»¹⁵ гэдгээ илэрхийлжээ. Тэр бас Афганистаны тусгаар тогтнол, бүрэн эрхэд гар сарвайх гаднын өнгөлзлөг эс зогсвол юуны өмнө хөрш зэргэлдээ ЗХУ, цаашилбал «баатарлаг Вьетнам, баатарлаг Куба, баатарлаг Этиоп болон Ангол, Палестиний арабчуудыг оролцуулан баатарлаг арабын улсуудын тусламж эрнэ»¹⁶ гэсэн нь эх орондоо шинэ нийгэм байгуулах гэсэн афганы олон сая ард иргэдийн чин эрмэлзлэлийг илэрхийлсэн үг юм.

Бабрак Кармаль АААН-ын 15 жилийн ойд зориулж хэлсэн үгэндээ: «БНААфГУ, ЗСБНХУ-ын хооронд 1978 оны 12-р сарын 5-нд гарын үсэг зурсан найрамдал, сайн хөрш, хамтын ажиллагааны гэрээ, НҮБ-ын дүрмийн 51-р зүйлд нийцүүлэн Афганистаны засгийн газар Зөвлөлтөөс хязгаарлагдмал тооны цэргийн анги ирүүлж гаднын түрэмгийллээс эрх чөлөө, тусгаар тогтнолоо хамгаалсан бөгөөд Афганистаны дэвсгэр нутгийн эсрэг гаднын түрэмгийлэл зогсож, энэ бүс нутагт энх тайван аюулгүй байдал баттайгаар тогтвол дээрх цэргийн анги Афганистаны нутгийг дуртайяа орхих болно. Харин ийм болзол хангагдаагүй цагт нэг хоногийн өмнө ч буцахгүй»¹⁷ гэжээ. Зөвлөлтийн цэргийн анги нь Афганистаны до-тоод дахь хувьсгалын эсэргүүчүүдийг устгах хэрэгт огт оролцоогүй бөгөөд гагцхүү гадаадын түрэмгийлэл тухайлбал Пакистаны зүгээс халдан довтолж байтаа хөлсний цэрэг, зэвсэгт дээрэмчдийн дайралтыг зогсоох гол үүрэгтэй юм. Одоогийн байдлаар ардчилсан Афганистаны бүрэлдэн тогтох үеийн хамгийн хүнд өдрүүд өнгөрснийг харгалзан, нөгөө талаар бүс нутагт олон улсын харилцааг улс төрийн зохицуулах аргаар хэвийн болгох сайн санааны үүднээс уг хязгаарлагдмал хэмжээний цэргийн ангийнхаа нэлээд хэсгийг ЗХУ буцаан татаад байна. Харин Афганистаны эсрэг зарлаагүй дайн хэрэг дээрээ олон улсын зэвсэгт интервенцийн хэлбэрээр өнөө хүртэл үргэлжилж ЗХУ-ын өмнөт хил дээр аюул занал учруулж байгаа тул ЗХУ цэргийн ангиа бүрэн татах үндэсгүй юм.

Хоёр улсын гэрээ хэлэлцээрээр хүлээсэн интернационалч үүргээ зөвлөлтийн засгийн газар урьдын адил нэр төртэй биелүүлснийг АНУ, бээжингийн эрх баригчдаас ашиглахыг оролдож санаачилсан «афганы хямрал» гэгч аандаа замхарч энэ бүс нутагт хэвийн байдал сэргэж буй хэдий боловч ах дүү зөвлөлтийн ард түмэн, Зөвлөлт засгийн газар хэрэгтэй цагт нь туслахад хэзээд бэлэн байгааг Л.И.Брежнев илэрхийлж хэлэхдээ: «Зөвлөлт-Афганистаны найрамдлын гэрээ, НҮБ-ын дүрэмд бүрэн нийцүүлэн бид үүргээ эцэст нь хүртэл биелүүлэх болно»¹⁸ гэсэн билээ. Энэ бол империализм, их гүрний жанжлах дээрэнгүй үзэлд өгсөн дорвитой няцаалт бөгөөд афганы дөрөвдүгээр сарын хувьсгалын ололтыг хамгаалах, түүний цаашдын ялалт, хөгжилтийг хангах нэг найдвар-

¹⁵Мөн тэнд. 24-р тал.

¹⁶Babrak Karmal's speeches. Kabul. 1980. p 85—86.

¹⁷Мөн зохиол. 63-р тал.

¹⁸Л. И. Брежнев. ЗСБН Казах улс, Казахстаны коммунист намын 60 жилийн ойн баярын хуралдаан дээр хэлсэн үг. («Үнэн». 1980 оны) наймдугаар сарын 31.

тай баталгаа юм. Хэрэв ийм баталгаагүй бол ямар аюул учирч болохыг дараахи баримтууд харууллаа. АНУ Иранаас татан буулгасан цэргийн төхөөрөмжөө Афганистанд шилжүүлэн байрлуулах арга хайж, бас тагнуулын төв газрынхаа Иранд байсан төвийг Ираны хувьсгалын дараагаар Пакистанд шилжүүлж тэндээс Иран, Афганистаны байдлыг хянаж байх болгожээ. Энэ тухай Пакистаны сонинд 1979 оны 6-р сард бичсэн байв. Америкийн тагнуулын төв газар тийнхүү Афганистаны хувьсгалын эсрэг зэвсэгт отрядуудыг Пакистаны нутаг дээр бэлтгэхэд гар бие оролцож мөнгө, хөрөнгө, зэр зэвсэг, түүний дотор хорт бодис бүхий тэсрэх гар бөмбөгөөр хангаж хятад «зөвлөгчүүдийг» тавьж байна.

АНУ тэргүүтэй империалиет хүчний талынхны эцсийн зорилт нь Афганистаны хувьсгалыг мөхөөх, тэр хувьсгалын дүнд тогтсон ардчилсан засгийг төрийн эргэлт хийж устгаад хуучин дэглэмийг сэргээхэд оршиж байлаа. Афганистаны хувьсгалын эсрэг гадаад хүчний дотор хятадын жанжлагчдын хагалан бутаргах үйл ажиллагаа онцгой байр эзлэнэ.

Хятадын жанжлагчид Пакистан дахь маогийн талыг баримтлагч шаолее жавид», «сорха», салан тусгаарлагч «сетапе мелли» гэх мэт нууц бүлэглэл болон «ах дүү лалын шашинтан» («хезбе ислами») гэдэг монархист үзэлт харгис байгууллагын тусламжтайгаар Хятад, Пакистантай хид залгах Бадахшан муж (хүн ам нь ихэвчлэн уйгур хотон)-ын үндэсний үзэлт салан тусгаарлагчдыг өөгшүүлэн дэвэргэж Памир дахь лалын тусгаар улс байгуулах нэрийдлээр тасдаж, «алдагдсан» нутаг дэвсгэрээ нэгтгэж хил хязгаараа тэлэх, тэгснээрээ афганы дөрөвдүгээр сарын хувьсгалд ноцтой цохилт өгөх бодлоготой юм. Афганистанд хувьсгал ялснаар ЗХУ-ыг Өмнөд Ази тийш «хөдөлгөхгүй», харин түүнд дайснагнасан «өргөн фронт»-ын нэг жигүүр гарган өмнө талаас нь таглах гэсэн бээжингийн бодлого нурсан учир хятадын эрх баригчид Афганы хувьсгалын эсрэг бодлогодоо түүний зэргэлдээх Пакистаныг ашиглаад зогсохгүй, 1979 оны 3-р сард Гератад, 1980 оны 2-р сард Кабулд гарсан хувьсгалын эсрэг үймээнийг зохион байгуулахад хятадын тагнуул туршуулууд шууд гар бие оролцсон ба тэдгээр хотуудын нууц агуулахаас хятадад үйлдвэрлэсэн буу зэвсэг олон гарчээ.¹⁹ Дөрөвдүгээр сарын хувьсгалаас хойш Афганистаны хувьд АНУ, Хятадын эрх баригчид зэргэд бодлого явуулж ирлээ. Тэд 1979 оны сүүлчээр бүрэн эрхт Афганистаны эсрэг «зарлаагүй дайн» дэгдээж үүний тул Пакистаны нутгийг түшиц газар болгоод тэнд тусгай бааз 30 гаруй, хуаран 30-ыг байгуулж Афганистанд нэвтрүүлэх хувьсгалын эсэргүү дээрмийн бүлэг байгуулж байна. Пакистаны хэвлэлд мэдээлснээр бол ийм армийг энэ оронд 380 мянга гаруй байгаа Афганистаны «дүрвэгсэд» гэгчдийн дотроос эмхлэн байгуулж байна. Зөвхөн сүүлийн нэг жил энд 30 мянга, Хятадад өөрт нь 40 мянга орчим дээрэмчид бэлтгэгдэж Синьзянд дээрэмчдийг бэлтгэх 7-8 бааз байгуулаад байна.²⁰

Пакистанд байрласан хэлсний дээрэмчид хувьсгалын эсэргүү нарт зориулан хятадаас «газар-агаар» маягийн пуужин, миномет, тийрдэггүй их буу, «АК-47» автомат зэрэг олон тооны буу зэвсэг, цэргийн ачааг ус

¹⁹С. Г. Юрков. Азия в планах Пекина. М. 1981. с. 119—120.

²⁰«Үнэн», 1980 оны нэгдүгээр сарын 23.

*Амины үед буюу 1979 оны арван хоёрдугаар сарын 27-оос өмнө дүрвэж гарсан эдгээр афганчуудаас сүүлийн үед хэдэн арван мянгаараа буцаж ирсэн бөгөөд буцаж ирэгчид өдрөөс өдөрт олширч байна. («Правда» 1981 оны нэгдүгээр сарын 19) Рейганы засаг захиргаа Афганистаны эсрэг зэвсэгт интервенцид оролцох явдлаа шинэ шатанд хүргэж Пакистанд үзүүлж байгаа иж бүрэн «тусламж» гэдгээ хоёр дахин нэмэгдүүлж тэнд АНУ-ын агаарын болон тэнгисийн цэргийн бааз байгуулах талаар идэвхтэй ажиллаж байна. («Үнэн» 1981 оны дөрөвдүгээр сарын 11).

(Энэтхэгийн далай), хуурай зам (каракорумын засмал)-ын аль алинаар зөөсөөр байна. Эдгээр зэвсгээр зэвсэглэсэн дээрэмчид Афганистаны нутагт байнга халдсаар буй нь НҮБ-ын ерөнхий Ассамблей 1974 онд баталсан түрэмгийллийн тодорхойлолтоор авч үзвэл жинхэнэ түрэмгийллийн баримт юм. АНУ-аас дээрх төрлийн зэвсгүүдээс гадна хөнгөн тэрэг, хүнд танк хүртэл нийлүүлж байгаа ба Иранаас татаж буулгасан цэргийн баазынхаа зэвсэг техникийг Пакистанд ойртуулж байхад Хятад нь Тайваний чиглэлээс татсан буу зэвсгээ Пакистанд илгээхээс гадна Синьзянд 10-12 дивиз, МИГ-1 маягийн нисэх онгоцны 4 эскадриля татаж аваачсан мэдээ байна.²¹ АНУ, хятадын цэргийн зөвлөгчүүд 70 мянган хүнтэй цэргийн ангийг Афганистаны эсрэг довтолгоонд бэлтгэж байгаа тухан Кубын «Гранма» сонинд мэдээлжээ. Ийнхүү АНУ, Хятад хоёр Афганистаны эсрэг зэвсэгт түрэмгийллийн замд орж Афганистанд аюул нөмөрсөн 1979 оны 12-р сарын эгзэгтэй үед Афганистаны засгийн газрын хүсэлтийг (урьд нь 13 удаа хүсэлт тавьжээ) хүлээн авч ЗХУ хязгаарлагдмал тооны цэрэг оруулжээ. Чухам энэ арга хэмжээ Афганистан орныг дөрөвдүгээр сарын хувьсгалаар сонгож авсан зам, түшиж нөхөрлөсөн хөршөөс нь салгаж хоёрдох «Кампучи» буюу «Чили» болгох аюулаас хэлтэлсэн юм. Үүнийг ч афганы ард түмэн, түүний удирдагчид үнэн зөвөөр нь ойлгож байна.

АААфсУ-ын Хувьсгалт зөвлөлийн дарга Бабрак Кармаль тусгаар тогтносон Афганистаны эсрэг АНУ-ын империалистүүд бээжинтэй болон Садат, Бегиний дэглэмийнхэнтэй сүлбээтэйгээр хийж байсан хуйвалдааныг тас цохисон явдлыг дөрөвдүгээр сарын хувьсгалын шинэ шатны нэг чухал үр дүн гэж үнэлжээ.²³

Афганистаны ард түмэн алдарт Саурын хувьсгалынхаа ололтыг ийнхүү дотоод гадаадын дайснаас авран хамгаалж тэдгээр дайсны учруулсан хүнд хохиролыг гэтлэн давж хувьсгалыг үргэлжлүүлэн аугаа их ЗХУ-тай холбоо найрамдлаа бэхжүүлсээр байна. Афганы хувьсгалын хоёр жилийн ойд зориулсан баярын хурал дээр ААН-ын төв хорооны ерөнхий нарийн бичгийн дарга БНААфгУ-ын хувьсгалт зөвлөлийн дарга ерөнхий сайд Бабрак Кармаль агуу их ЗХУ-тай ах дүүгийн найрамдал үр шимт хамтын ажиллагааг бэхжүүлэн хөгжүүлэх талаар ярихдаа: «Энэ найрамдал бол шинэ Афганистаны улс төрийн бүх бодлогын тулгын чулуу гэж нэрлэсэн юм. Зөвлөлт, афганы ард түмний ах дүүгийн найрамдлыг бэхжүүлэх, зөвлөлт, афганистаны харилцаа, тал бүрийн хамтын ажиллагааг бататган цаашид гүизгийрүүлэхэд чухал үе шат болсон Зөвлөлт-Афганистаны 1980 оны аравдугаар сарын 16-ны хэлэлцээний дунд Б. Кармаль, Л.И.Брежнев нар гарын үсэг зурсан ЗХУ, БНААфгУ-ын хамтарсан мэдэгдэлд: «...дөрөвдүгээр сарын хувьсгалын хоёрдугаар шат нь зөвлөлт-афганистаны харилцааг тал бүрээр хөгжүүлэх хамгийн таатай нөхцөл бий болгож байгааг болон ах дүүгийн найрамдал, хувьсгалт эв санааны нэгдэл, интер-национализмын зарчмын үндсэн дээр тус хоёр орны харилцааг хойшид ч тал бүрээр бэхжүүлэн хөгжүүлэх шийдвэр төгс байгааг хоёр тал онцлон тэмдэглэв»²⁵ гэжээ.

Зөвлөлт-Афганы эвт хөршийн нөхөрсөг харилцаа өдрөөс өдөрт хөгжиж буйн нэг шинэ илрэл нь ЗХУКН-ын XXVI их хуралд ААН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Бабрак Кармаль тэргүүтэй төлөөлөгчид оролцсон явдал бөгөөд XXVI их хурлын тайлан илтгэлд

²¹ «Проблемы Дальнегс Востока», 1980. № 2. с. 106.

²³ «Правда об Афганистане» М., 1980. с. 103.

²⁴ «Правда». 1980 оны дөрөвдүгээр сарын 27.

²⁵ «Үнэн», 1980 оны аравдугаар сарын 21.

зөвлөлтийн цэргийн тухайд дурдахдаа Афганистанд хувьсгалын эсэргүү дээрэмчдийг гаднаас оруулахыг бүрэн зогссон цагт афганы засгийн газартай тохиролцсон үндсэн дээр ЗХУ цэргээ гаргахад бэлэн байгаа бөгөөд Зөвлөлт засгийн газар энэ зарчимт байр сууриа хатуу чанд баримтлах тухай²⁶ дахин яруу тодоор тунхаглалаа.

Афганистаны ардын ардчилсан нам, БНААфгУ-ын засгийн газар олон улсын тавцан дээр энх тайвнаар зэрэгцэн орших, эвсэлд үл нэгдэх нааштай идэвхит бодлогыг гадаад бодлогынхоо гол үндэс болгож бүс нутагтаа болон хөрш орнуудтайгаа харилцан ойлголцох уур амьсгал бүрдүүлж оршин байгаа зөрчил маргааныг улс төрийн зохицуулх аргаар яаралгүй ажил хэрэгч бүтээлчээр шийдвэрлэх чиг шугам баримталж байна. 1980 оны 5-р сарын 14-нд Афганистаны засгийн газар мэдэгдэл гаргаж Иран, Пакистантай харилцаагаа улс төрийн аргаар хэвийн болгох, үүний тул хоёр этгээдийн хэлэлцээрт урьдчилсан ямар ч болзол тавилгүй гагцхүү Афганистаны эсрэг дайсагнах ажиллагаатай зэрэгцүүлэлгүй явуулж тулгамдсан болон зарим хуучин хүлээгдсэн асуудлыг хэлэлцэж шийдвэрлэх тухай чухал санал дэвшүүлсэн билээ. Уг мэдэгдэлд Пакистан зэрэг оронд алив шалтгаанаар түр оршин суугаа афганчуудыг эх орондоо буцаж ирэхийг дахин уриалж тэднийг БНААфгУ-ын засгийн газрын 1980 оны 1-р сарын 1-ний мэдэгдэл ёсоор өршөөл үзүүлж амьдрал ахуйг нь тусгайлан харж үзэх тухайгаа баталж тэднийг буцаах талаар Пакистаны болон бусад орны засгийн газрууд зохих туслалцаа үзүүлэхийг хүсчээ.

Бүс нутгийн олон улсын харилцааны уур амьсгалыг бүхэлд нь тогтворжуулах, хол ойрын орнуудтай хоёр талын харилцааг хэвийн болгоход чиглэгдсэн өгүүлэн буй улс төрийн аргаар зохицуулах хөтөлбөрөөр дэвшүүлсэн санал санаачлага нь 1980 оны 4-р сарын 27-нд нийтлэгдсэн «Дөрөвдүгээр сарын хувьсгалын хоёр жилийн ойд зориулсан ААН-ын Төв Хорооны сэдэв»-т тусгагдсан чухал саналыг хэрэгжүүлэхэд бодит алхам болно. Афганистаны энэхүү энх тайванч гадаад бодлого, үр бүтээлтэй санаачлага нь Ази, даян дэлхийн энх тайван, аюулгүй байдал, тогтвортой байдлыг хангахад түүний оруулж байгаа чухал хувь нэмэр бөгөөд гагцхүү тийм нөхцөлд л Афганистанд шинэ нийгэм байгуулах ААН-ын туйлын зорилго биелэгдэх бололцоотойг ойлгодог Афганистаны анд нөхөд түү- ний дотор монголын ард түмэн баатарлаг афганы ард түмний хувьсгалт ололт амжилтыг талархан дэмждэг юм.

Э. Пунцаг

АПРЕЛЬСКАЯ РЕВОЛЮЦИЯ АФГАНИСТАНА

(Резюме)

В данной статье автор коснулся процесса развития апрельской (саурской) революции Афганистана, ставшей непосредственным продолжением и неотъемлемой составной частью мирового революционного процесса начало которому положила Великая Октябрьская революция в России. Открывшая новую страницу в истории Афганистана, совершенная по

²⁶Л. И. Брежнев. ЗХУКН-ын Төв Хорооны тайлан, намын дотоод гадаад бодлогын ээлжит зорилт. УБ. 1981. 21-р тал.

воле его трудового народа афганская революция 1978 года, победившая под руководством НДПА, в силу внутренних и внешних факторов на данном этапе своего развития носит национально-демократический характер. Вместе с тем, автор обращает особое внимание на антиимпериалистическую направленность афганской революции, на ее социальный аспект: строить новое общество без эксплуатации человека человеком-принцип, который осуществляется в социалистическом обществе.

Именно Афганистан, как одна из первых стран в Азии, которая под светом Великого Октября уже на пороге 20-х годов разорвала цепи империализма, имеет много общего с Монгольской Народной Республикой в революционном развитии общества и историческом процессе национально-освободительного движения в целом.

Остановливаясь на двух этапах апрельской революции, автор приводит конкретные данные, убедительно показывающие те шромные успехч, которых добилась ДРА в период общедемократического этапа революции и преодолевая объективные трудности, связанные с отсталостью стракы и сопротивлением лишенных революцией власти эксплуататоров и предателей револции, подчеркивает значение второго этапа, начавшегося устракием аминовского режима 27 декабря 1979 г.

Автор подвергает справедливой критике необъявленную агрессивную войну, развязанную против афганской революции реакционными силами империализма США и китайских гегемонистоз, главным плацдармэм которых служит Пакистан, и высоко ценит роль военной помощи Советского Союза, гарантирующего безопасность апрельской революции в Афганистане. Своим пребыванием в Афганистане ограниченный контингент советских войск защищает революционный Афганистан, его независимость и суверенитет от реальной угрозы извне.

В заключение автор подчеркивает, что правительство возглавляемое тов. Бабраком Кармалем, формируя национально-патриотический фронт, уверенно проводит в стране политику по осуществлению идеалав апрельской революции, а в области внешней политики проявляет неустанную инициативу по мирному урегулированию вопросов, возникших вокруг Афганистана. Ярким свидетельством этой инициативы является предложение правительства ДРА от 14 мая 1980 г., направленное на установление мира и добрососедства в странах данного региона.